

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2012 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн
тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг батлах тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тушаалыг үндэслэн эрдэм шинжилгээний ажилтны аттестатчиллыг хуульд заасан хугацаанд тогтмол явуулж, зэрэг дэв тогтоож, үр дүнг тооцож байхыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.
3. Энэ тушаалтай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны “Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн шалгуур үзүүлэлтийг батлах тухай” 201 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Л.ГАНТӨМӨР

1. Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт

Эрдэм шинжилгээний тэргүүлэх, ахлах, дэд ажилтан гэж тухайн зэрэг дэвийн нийтлэг шаардлага болон шалгуур үзүүлэлтийг хангасан эрдэм шинжилгээний ажилтныг хэлнэ.

2. Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн нийтлэг шаардлага

а) Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан дор дурьдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

1. Докторын /Ph.D/-ын зэрэгтэй, докторын зэрэг хамгаалснаас хойш 8-аас доошгүй жил судалгааны чиглэлээрээ дагнан ажилласан;
2. Судалгааны шинэ чиглэл санаачлах, хэрэгжүүлэх чадавхитай (олон улсын болон үндэсний судалгааны тэтгэлэг, төсөл хэрэгжүүлэхээр шалгарч гэрээт, захиалгат ажлыг гүйцэтгэн эрдэм шинжилгээний байгууллагадаа санхүүгийн эх үүсвэрийг бий болгосон), эрдэм шинжилгээний байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан, лаборатори, кабинет байгуулсан, шинэ тоног төхөөрөмж авсан г.м.) ;
3. Эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, дадлагажуулж, өөрийн шавь сургалтыг бий болгосон;
4. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдыг үлгэрлэн манлайлдаг, багаар ажиллах чадвартай;
5. Патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан эсвэл нэг сэдэвт бүтээл нийтлүүлсэн;

б) Эрдэм шинжилгээний ахлах ажилтан дор дурьдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

1. Докторын/Ph.D/-ын зэрэгтэй, докторын зэрэг хамгаалснаас хойш 6 -аас доошгүй жил судалгааны чиглэлээрээ дагнан ажилласан;
2. Шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил, эрдэм шинжилгээний бага хурал, семинар удирдах арга барил эзэмшсэн, багаар ажиллах чадвартай;
3. Эрдэм шинжилгээний ажилтныг шинэ мэдээллээр хангах, дадлагажуулах, тэднийг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах чиглэлээр ажилласан;
4. Гадаад хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн (Эрдэм шинжилгээний ажилтан гадаад оронд бакалаврын ба түүнээс дээш түвшний сургалт буюу Монгол Улсын гадаад хэлний магадлан итгэмжлэгдсэн дээд сургуулийг амжилттай төгссөн бол гадаад хэлний

үзүүлэлтийг хангасанд тооцно. Эрдэм шинжилгээний ажилтан аттестатчилаар шалгуулах гадаад хэлийг өөрөө сонгоно).

5. Мэргэжлийн багаж, тоног төхөөрөмж, хэрэглээний программуудыг эзэмшсэн;

6. Эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх, дадлагажуулж, өөрийн шавь сургалтыг бий болгосон;

7. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, бусдыг үлгэрлэн манлайлдаг;

в) Эрдэм шинжилгээний дэд ажилтан дор дурьдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

1. Магистраас доошгүй зэрэгтэй,

2. Шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэх арга зүй эзэмшсэн, багаар ажиллах чадвартай;

3. Мэргэжлийн багаж, тоног төхөөрөмж, хэрэглээний программуудыг эзэмшсэн;

4. Гадаад хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн (Эрдэм шинжилгээний ажилтан гадаад оронд бакалаврын ба түүнээс дээш түвшний сургалт буюу Монгол Улсын гадаад хэлний магадлан итгэмжлэгдсэн дээд сургуулийг амжилттай төгссөн бол гадаад хэлний үзүүлэлтийг хангасанд тооцно.Эрдэм шинжилгээний ажилтан аттестатчилаар шалгуулах гадаад хэлийг өөрөө сонгоно).

5. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг;

6. Судалгааны чиглэлээрээ сүүлийн 4 жил ажилласан.

г) Эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтаны зэрэг дэвийн орон тоонд ажиллах хүн дор дурдсан нийтлэг шаардлагыг хангасан байна:

1. Бакалавраас доошгүй боловсролын зэрэгтэй;

2. Өөрийн судалгааны ажлын чиглэлээр арга зүй эзэмшсэн, багаар ажиллах чадвартай;

3. Мэргэжлийн багаж, тоног төхөөрөмж, хэрэглээний программыг эзэмшсэн;

4. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг;

5. Гадаад хэлний зохих мэдлэг эзэмшсэн.

3. Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн шалгуур үзүүлэлт

Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэв	Шалгуур үзүүлэлт
Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан	<p><u>Сүүлийн 4 жилд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Эрдэм шинжилгээний өгүүлэл 8-аас доошгүйг нийтлүүлсэн байх, Үүнээс: Мэргэжлийн үнэлгээнд үндэслэн сонгон шалгаруулж хэвлэдэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд-1, олон улсын хурлын эмхэтгэл болон гадаадын сэтгүүлд 3-аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн; - Эрдэм шинжилгээний бүтээлээс нь дотоод, гадаадын судлаачдын авсан ишлэлийн тоо 10-оос доошгүй байх; - Нэг сэдэвт бүтээл, ном, сурах бичиг 3-аас доошгүйг хэвлэн нийтлүүлэхэд зохиогч, хамтран зохиогчоор ажилласан буюу оюуны өмчийн хамгаалалт хийсэн хоёроос доошгүй бүтээлийн үр дүн нь инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болсон; - Доктор, магистрийн 3-аас доошгүй дипломын ажлын удирдагч, шүүмжлэгч, зөвлөхөөр ажилласан; - Олон улс, бүс нутаг, үндэстний болон салбарын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор 3-аас доошгүй захиалгат, гэрээт, төсөлт ажлыг удирдсан, гүйцэтгэсэн;
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан	<p><u>Сүүлийн 4 жилд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Эрдэм шинжилгээний өгүүлэл 6-аас доошгүйг нийтлүүлсэн байх, Үүнээс: Мэргэжлийн үнэлгээнд үндэслэн сонгон шалгаруулж хэвлэдэг олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд 1, олон улсын хурлын эмхтгэл болон гадаадын сэтгүүлд 2-оос доошгүй өгүүлэл нийтлүүлсэн ; - Нэг сэдэвт бүтээл, ном, сурах бичиг 2-оос доошгүй хэвлэн нийтлүүлэхэд зохиогч, хамтран зохиогчоор ажиллаж, хэвлэн нийтлүүлсэн буюу оюуны өмчийн хамгаалалт бүхий нэг бүтээлийн үр дүнгээрээ инноваци хэрэглээ, үйлчилгээ болсон; - Эрдэм шинжилгээний бүтээлээс нь дотоод, гадаадын судлаачдын авсан ишлэлийн тоо 8-оос доошгүй байх; - Доктор, магистрийн 2-оос доошгүй дипломын ажлыг удирдсан, шүүмжилсэн буюу зөвлөсөн; - Олон улс, бүс нутаг, үндэстний болон салбарын хэмжээний 2-оос доошгүй захиалгат, гэрээт, төсөлт, сэдэвт ажлыг гүйцэтгэсэн; - Тухайн судалгааны чиглэлээрээ 2-оос доошгүй судлаачийг бэлтгэсэн байх;

<p>Эрдэм шинжилгээний дэд ажилтан</p>	<ul style="list-style-type: none">- Эрдэм шинжилгээний ажлын 2-оос доошгүй арга зүйг эзэмшиж, эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, үр дүнг тайлагнасан;- Эрдэм шинжилгээний 4-өөс доошгүй өгүүлэлийн зохиогч, хамтран зохиогчоор ажиллаж, хэвлэн нийтлүүлсэн;- Эрдэм шинжилгээний хуралд 6-аас доошгүй илтгэл тавьсан;- Шинэ хэрэглээ, үйлчилгээ бий болгох чиглэлээр эрдэм шинжилгээний 2-оос доошгүй ажил гүйцэтгэсэн, оролцсон (зохион бүтээх, технологи нутагшуулах, лаборатори байгуулах г/м).- Олон улс, бүс нутаг, үндэсний болон салбарын хэмжээний захиалгат, гэрээт, төсөлт, сэдэвт ажлыг гүйцэтгэсэн.
---	---

-----oOo-----